Аймгийн Засаг даргын тамгын газар нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны А/39 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 380,425.6 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 8.3 | 208.8 | 200.5 |
| Авлага | 30,267.5 | 64,071.5 | 33,804.0 |
| Бараа материал | 492,539.2 | 552,390.5 | 59,851.3 |
| Үндсэн хөрөнгө | 3,178,249.6 | 3,464,819.5 | 286,569.8 |
| **Нийт хөрөнгө** | **3,701,064.7** | **4,081,490.2** | **380,425.6** |
| Өр төлбөр | - | 5,528.4 | 5,528.4 |
| **Засгийн газрын оролцоо** | **3,701,064.7** | **4,075,961.8** | **374,897.2** |
| Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/ | 1,485,687.3 | 1,485,687.3 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 721,548.5 | 1,090,842.1 | 369,293.7 |
| Тайлант үеийн үр дүн | 369,293.7 | 374,897.2 | 5,603.5 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,124,535.2 | 1,124,535.2 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3,701,064.7** | **4,081,490.2** | **380,425.6** |

Дээрх хүснэгтээс харахад өсөлтийн дийлэнх хувийг авлага, бараа материал, үндсэн хөрөнгө данс эзэлж байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 25-ны 3 дугаар тогтоолоор Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг татан буулгасантай холбоотой тус байгууллагын тайлангаарх 2,530.0 мянган төгрөгийн авлага, 70,201.3 мянган төгрөгийн бараа материал, 485,037.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 5,528.4 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлэн авсантай холбоотой тус дансны үлдэгдэл өссөн.

Мөн авлагын үлдэгдэлд 60,121.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авлага, 1,420.0 мянган төгрөгийн томилолтын урьдчилгааны авлага байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,012,511.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 807,664.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,820,176.6 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 232,279.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,032,455.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,032,455.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 17,624.9 мянган төгрөг нийт 3,050,080.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 2,774,028.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 276,052.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,725,658.1 | 1,504,547.2 | 221,110.9 | 87.2% |
| 2 | 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 1,000.0 | 142.0 | 858.0 | 14.2% |
| 3 | 80305 | Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал | 2,000.0 | 1,750.0 | 250.0 | 87.5% |
| 4 | 80309 | Уналга, цугларалт бэлтгэл сургалтын зардал | 48,500.0 | 48,498.8 | 1.2 | 100.0% |
| 5 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 76,128.5 | 75,982.6 | 145.9 | 99.8% |
| 6 | 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 794,600.0 | 738,549.0 | 56,051.0 | 92.9% |
| 7 | 81410 | Засгийн газрын зээл | 344,361.0 | 344,361.0 | | |
| 8 | 81549 | Ахмадын сан | 10,208.3 | 10,208.3 | - | 100.0% |
| 9 | 82801 | Улсын их баяр наадам | 50,000.0 | 49,989.3 | 10.7 | 100.0% |
| | | **Дүн** | **3,052,455.9** | **2,774,028.2** | **278,427.7** | **90.9%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 35,303.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 113,122.8 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 874,901.4 мянган төгрөг нийт 1,023,327.4 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс 962,424.3 мянган төгрөгийг зарцуулж 60,265.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 9/190 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3,810,412.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,810.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих бодлого, чиглэл", А/89 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг баталсан.

Дээрх бодлого чиглэл, зааврыг хэрэгжүүлж, шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим сорилыг гүйцэтгэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Түлш, шатах тослох материалын зарцуулалтыг өмнөх оноос 13,000.3 мянган төгрөгөөр өсгөж, төсвийг хэмнэн ажиллах арга хэмжээ авч ажиллаагүй.

Байгууллагын батлагдсан төсвөөс 2,091.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авч зарцуулсан.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Түлш, шатах тослох материалын зарцуулалтыг хэмнэн ажиллаагүй зөрчилд 1 албан шаардлага, бэлэг худалдан авсан зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 1,560,500.0 | 3 | 1,560,500.0 | 100% |
| **Нийт дүн** | **3** | **1,560,500.0** | **3** | **1,560,500.0** | **100%** |

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалт, холбогдох журам, заавартай хэрхэн нийцэж байгааг авч үзэх болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,420.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан.

Үүнд: Тайлант оны эцэст төлсөн томилолтын урьдчилгааг урьдчилж гарсан зардлаар бүртгэв.

Аудитаар нийт 5,866.7 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 2,973.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 2,892.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага нь орон сууцанд амьдардаг албан хаагч нарт 2,520.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгосон.

Цалингаас суутгах урьдчилгаа, хувь хүний хадгаламжийн суутгалыг 453.9 мянган төгрөгөөр дутуу суутгасан.

### 5.2 Албан шаардлага

Туслах аж ахуйн малчныг үндсэн үйл ажиллагааны зардлаас 2,892.8 мянган төгрөгөөр цалинжуулсан.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| дааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бүртгэл буруу | 1 | 1,420.0 | - | - | 1 | 1,420.0 | 1 | 1,420.0 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **1,420.0** | **-** | **-** | **1** | **1,420.0** | **1** | **1,420.0** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | 3 | 5,866.7 | 2 | 2,973.9 | 1 | 2,892.8 | | | | | | |
| **Дүн** | **3** | **5,866.7** | **2** | **2,973.9** | **1** | **2,892.8** | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Зөрчил | 2 | 15,091.3 | 1 | 2,091.0 | 1 | 13,000.3 | - | - |
| **Дүн** | **2** | **15,091.3** | **1** | **2,091.0** | **1** | **13,000.3** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **2** | **15,091.3** | **1** | **2,091.0** | **1** | **13,000.3** | **-** | **-** |

# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2023 оны 03 сарын 20 өдөр  Дугаар 99/А2370448  Чингис хот

ХЭА-2023/35/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Цалингийн урьдчилгаа, хадгаламжийг дутуу суутгаж, 453.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Цалингаас дутуу суутгасан 453.9 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ОЮУНТУЯА

АУДИТОР  Б.АРИУНАА

232350266

Монгол Улс. Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 03 сарын 20 өдөр | Дугаар 100/A2370448 | Чингис хот

ХЗА-2023/35/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Орон сууцанд амьдардаг албан хаагч нарт 2,520.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.3-т "Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно." гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ажилтнуудад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлтийн 2,520.0 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

АУДИТОР Б.АРИУНАА

2317144297
CIOA0046-3074082

232350269

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 03 сарын 20 өдөр Дугаар 101/А2370448 Чингис хот
ХА-2023/35/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд байгууллагын батлагдсан төсвөөс 2,091.0 мянган төгрөгийг ажилтнуудын хүүхдийн бэлэг худалдан авахад зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэснийг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Бэлгийн үнэ 2,091.0 мянган төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

АУДИТОР Б.АРИУНАА

2317144207
СКО 50046 9074082

232350272

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 03 дугаар сарын 20 Дугаар 150/A2370448 Чингис хот

ХЭА-2023/35/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Туслах аж ахуйн малчинд 2,892.8 мянган төгрөгийн цалинг үндсэн үйл ажиллагаанаас олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т "Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно." гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бус зарцуулсан" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Туслах үйл ажиллагаанд үндсэн үйл ажиллагааны зардлаас зарцуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг АЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

АУДИТОР Б.АРИУНАА

2317144297

23234041Ч

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 20 Дугаар 151/АО370448 ХЭА-2023/35/НА-СТА-ТШЗ Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түлш, шатах тослох материалын зарцуулалтыг өмнөх оноос 13.0 сая төгрөгөөр өсгөж, төсвийг хэмнэн ажиллах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэснийг мөрдөн ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тээвэр шатахууны зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилладаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг АЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

АУДИТОР Б.АРИУНАА

2317141297
ГЮА3046 9074082

23234041 7